

Манмин Мэдээ

№ 54 2015 оны 1-р сарын 4

Тэргүүн пасторын Мэндчилгээ

“Бос, гэрэлт. Учир нь чиний гэрэл ирж, ЭЗЭНий цог жавхлан чиний дээр мандаж байна. Үзэгтүн, газрыг харанхуй бүрхэн гүн харанхуй хүмүүсийг хучсан. Гэвч ЭЗЭН чиний дээр мандан, Түүний цог жавхлан нь чиний дээр үзэгдэнэ. Үндэстнүүд чиний гэрэл уруу, хаад нь чиний мандах туяа уруу ирнэ” (Исаиа 60:1-3).

Хайрт итгэлийн ахан дүүс нар минь! Дахин ирэх Эзэнийг угтахын тулд эцсийн үеийн хүсэл зорилгыг биелүүлэхийн төлөө 1982 онд Манмин төв сүмийг босгон байгуулж өнөөдрийг хүртэл удирдан замчилсан Бурхан Аавдаа бүхий л алдар ба талархлыг өргөө!

Сүм байгуулагдсаны 32 жилийн ой тохиож буй 2014 онд Бурхан ‘Би хэрэгжүүлнэ’, ‘Үйлчлэл’, ‘Гэрэлтэх Өргөө’, ‘Дахин бүтээх хүч’ гэсэн дөрвөн залбирлын сэдвийг сүмд өгсөн билээ. Энэ жилийн турш Бурхан Манминд сүнсээр өсөх, Тэнгэрийн орны хамгийн гайхамшигтай сайхан газар болох Шинэ Иерусалимд орох итгэл найдвараар дүүрэн байх ивээлийг буулган өгсөн юм.

Цаашдаа 2015 онд дахин бүтээх хүчээр дамжуулан хүний төсөөллөөс даван гарсан ивээл ерөөлийг авч Бурханд гайхамшигтай алдрыг өргөх болно. Тиймээс 2015 онд Бурхан бидэнд ямар залбирлын сэдэв өгсөн, Түүний бидэнд өгөхөөр бэлдсэн байгаа ивээл ерөөлүүдийг авах арга замыг харцгаая!

Нэгдүгээрт “Алдар” – бид хоньчинтойгоо улам бүр илүү их нэгдэж Бурханд төгс “алдрыг” өргөх ёстой

Хаггай 2:9 д “Энэ өргөөний хожмын сүр жавхлан, урьдынхаасаа илүү агуу байх болно,” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаад “Энэ газарт Би амар тайвныг өгнө” гэж түмэн цэргийн ЭЗЭН тунхаглаж байна гэв” гэсэн байдаг.

Дэлхий дээрх үй олон сүмүүд байдаг ч Манмин төв сүм нь Бурханы авралын зорилгын төлөө Өөрөө босгон байгуулсан юм. Энэ сүм нь эцсийн үеийн авралын зорилгийг гүйцэлдүүлж, амьд оршигч Бурханыг төгс алдаршуулахын тулд байгуулагдсан билээ.

Тиймээс хоньчиноор дамжуулан Бурханы шударга байдлыг, агуу их эрх мэдэлт хүчийг гэрчлэн харуулж, Бурханы сэтгэлийн гүнийг хүртэл ойлгох сүнслэг урсгалыг зөвшөөрч Манминд өгсөн билээ. Мэдээж Бурхан Манмины олон улсад үйлчилсэн үйлчлэл бүрээр алдаршиж байсан бөгөөд ялангуяа Израйльд эрх мэдэлт хүчийг үзүүлж, ариун зар мэдээг гараахад гайхалтайгаар алдаршсан. Гэвч Бурхан үүнээс их

агуу гайхамшгуудыг үйлдэж алдрыг авахыг хүсч байна.

Тиймээс бүх үндэстний нүдэн дээр ил болох тул хамгийн сүүлчийн алдар нь урьд урьдынхтай харьцуулшгүй агуу байх бөгөөд амьд оршигч Бурхантай уулзах болно. 2015 онд бид бүхэн хоньчинтойгоо улам илүү нэгдэж, Бурханы бидэнд бэлдсэн гайхамшигт ерөөлийг авч, Бурханд төгс алдрыг өргөх хэрэгтэй.

Хоёр дах нь ‘Үр жимс’ – Бурханы хүсч байгаа тэр л үзэсгэлэнтэй сайхан ‘үр жимс’ гаргацгаая

1 Тесалоник 5:23-г уншвал “Амар тайвны Бурхан Өөрөө та нарыг бүрэн ариусгаг. Сүнс, сэтгэл, бие тань бидний Эзэн Есүс Христийг ирэхэд бүрэн хамгаалагдсан бөгөөд гэм зэмгүй байх болтугай” гэсэн байдаг.

Бурханы хүсэл бол хүн төрлөхтөнийг боловсруулж дасгалжуулан төгс үр жимс гарган сүнслэг болгох явдал юм. Хоньчны нулимс, золиосны хүчээр хүмүүсийг илүү гүн сүнслэг түвшин рүү, төгс сүнс рүү оруулах сүнслэг урсгал бий болсон билээ. Бид сүнслэг урсгал дунд амжилттай сайн яваад зогсохгүй гар алчуурын хүчээр дэлхий рүү давшин орж үй олон хүмүүсийг Эзэн рүү удирдан замчлах хэрэгтэй. Ингэж маш олон хүмүүсийг төгс сүнс рүү оруулж сайн, гайхамшигтай үр жимс гаргах хэрэгтэй.

Бурхан энэ сүмд өгөгдсөн эцсийн үеийн хүсэл зорилго нь хоньчины ганц хүчээр бус, мөн хэдхэн төгс сүнслэг итгэлтэй хүмүүсүүдээр биелэгдэх зүйл биш юм. Маш олон сүнслэг итгэл бүхий Бурханыг баярлуулсан үй олон хүмүүсүүдээр энэ агуу ажлыг биелүүлэх болно.

Гуравдугаарт, Бурханы алдар орших ‘гэрэлтэх ариун өргөө’ барьцгаая

Илчлэлт номын 21:10-11д “Тэр намайг сүрлэг өндөр уулан дээр Сүнс дотор аваачаад Бурханаас гарч, тэнгэрээс буун ирж буй ариун хот Иерусалимыг үзүүллээ. Түүнд Бурханы алдар нь байлаа. Гялбаа нь үнэт чулуу мэт бөгөөд талст шиг тунгалаг хас чулуу мэт байв” гэсэн байдаг.

Шинэ Иерусалимыг санагдуулам гайхамшигтай, үзэсгэлэнтэй гэрэлтэх ариун өргөөг барих арга замыг

Бурхан бий болгосоор байгаа билээ. Бурхан ариухан хүүхдүүдээсээ магтаал хүндэтгэлийг авч алдарших газар болох гэрэлтэх ариун өргөөтэй болно гэдэгт итгэлтэй байгаа. Канаан сүмийн болоод гэрэлтэх өргөөний энэ агуу том төслийн барилгын ажил ивээл орж ирэнгүүт эхлэх гэж байгаа. Би та бүхнийг Бурханы хүслийн дагуу төгс сүнс, сүнслэг зүрх сэтгэлтэй болж алдрыг гэрэлтүүлж цацруулж бид бүхэнтэй нэгдээсэй хэмээн хүсч ятгаж байна.

Хамгийн сүүлд, хүний төсөөлөлөөс даван гарсан дахин бүтээх хүч бий болно

‘Дахин бүтээх хүч’ нь Бурханы бүтээсэн тэнгэрийн орон, дэлхий ертөнц, түүнд орших бүх зүйлийг дахин бүтээх хүчийг хэлж байгаа юм (Эхлэл 1:3). Дахин бүтээх хүч нь Хоньчины хайраар дамжуулан шударга ёсны дагуу хүний зүрх сэтгэл өөрийнх нь хүслийн дагуу (өөрөөр хэлбэл хүний өөрийнх нь чөлөөт сонголтон дотор нь) өөрчилж болохыг батлан харуулсан билээ. Цаашдаа энэ хүч маш гайхамшигтайгаар гарах болно.

Өнөөдрийн дэлхий ертөнц гэм нүгэл, хорон муугаар дүүрч, сайхан сэтгэлийг олоход маш хэцүү болсон байна. Тиймээс цөөхөн хүн Эзэнийг хүлээн авч байна. Гэсэн ч дахин бүтээх хүч нь аврал авах боломжгүй хорон муу хүмүүсийг тэр ч байтугай Искарятын Иудас шиг хүнийг хүртэл өөрчилж, Бурханы нэрийн өмнө өвдөг сөгдүүлэх болно. Ингэж бүх үндэстнийг авралын зам руу замчлан удирдаж, хариулт болоод ивээлийг буулгах юм. Энэ үед маш олон итгэгчид Шинэ Иерусалимд орж, Бурханыг төгс алдаршуулах болно.

Хайрт пасторууд, 10000 гаруй салбар сүмийн итгэгчид ээ, 2015 онд Бурханы эцсийн үеийн авралын зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд бидэнд хийх зүйл маш их байгаа шүү. Би Их Эзэнийхээ нэрээр та бүхнийг сүнсрүү, төгс сүнсрүү маш хурдан давшин орж, эцсийн үеийн авралын зорилгыг хоньчинтойгоо хамт гүйцэлдүүлж, Бурханы алдраар дүүрэн Шинэ Иерусалимд хамтдаа орохыг хүсэн гуйж, залбирч байна.

И Жей руг Тэргүүн пастор
2014 оны 12 сарын 28



Зөв байгчийн үр жимс амар тайванд таригддаг

“Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм” (Иаков 3:18).



И Жей руг пастор

Иаков 3:17-18д “Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж. Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм.”

17-р ишлэлд өгүүлж байгаа амар тайван гэдэг нь бусад хүмүүстэй эв нэгдэлтэй байхыг, 18-р ишлэлд Бурхантай эв нэгдэлтэй байх тухай өгүүлж байна. Бурхантай эв нэгдэлтэй байна гэдэг нь Бурхан бидний хооронд ямар нэгэн саад болох гэрийн хана байхгүй байхыг хэлж байгаа. 17-р ишлэлд дурдсан ариун, амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй гэсэн бүх үр жимсийг боловсруулсан цагт бид амар тайвныг бүтээгчид болж чадна. Амар тайван дотор юу тарина түүнийгээ зөвт байдалд хурааж авна. Тэгвэл яаж амар тайван дотор таригдсан зүйлийг зөвт байдалд хурааж авахыг үзэцгээе.

1. Амар тайваныг бүтээгчид

Олон хүн Бурханы өмнө эв түнжин туутай мөртлөө, хүмүүстэй л эв нэгдэлтэй байх талаар боддог. Яг үнэндээ тэд үнэнийг зөрчиж, зөвт бус байдалтай эвлэрч байхдаа хэн нэгэнтэй эв нэгдэл хагараагүй амар тайван байгаа учраас өөрсдийгөө ухаантай гэж боддог. Эсвэл заримдаа бусадтай харилцах явцдаа эв нэгдлийг сахидаг ч Бурханы Үгийг зөрчдөг. Үүнийг илэрхийлэх маш сайн жишээ бол бусдын өр зээлийн төлөө батлан даагч болох эсвэл хүнд мөнгө зээлдүүлэх асуудал юм.

Бурхан айлдахдаа Сургаалт Үгс 22:26д “Бусдын өмнөөс гар барин амлаж, мөн өртэй хүний төлөө батлан даалт гаргадаг хүн байх хэрэггүй”, Ром 13:8д “Нэг

нэгэндээ хайртай байхаас өөр хэнд ч ямар ч өргүй бай...” гэсэн байдаг. Гэтэл таны хамгийн дотны найз чинь таныг батлан даагч болооч, эсвэл мөнгө зээлдүүлээч гэж гуйхад зарим нь энэ үгийг мартдаг. Бусдын өр зээлийн төлөө батлан даагч болно гэдэг нь та өөрөө өөрийгөө хүнд байдалд оруулж байгаа бөгөөд тийм ч ухаалаг хэрэг биш юм. Магадгүй та түүнд хайртай учраас хэрэгтэй зүйлийг нь л өгсөн байх. Өөрөөр хэлбэл мөнгөнөөс болоод та хүнд байдалд орвол та хоёрын дунд дайсагнал, үзэн ядалт бий болно гэсэн үг. Тэд Бурханаас өмнө бусад хүмүүстэй эв нэгдэлтэй байх тухай боддог учраас ийм юм тохиолддог байна.

Түүнчлэн өөрийн эрх ашгийн төлөө дэлхийтэй эвлэрэх, Бурханы алдрын төлөө эв нэгдлийг сахих хоёрыг маш сайн ялгадаг байх хэрэгтэй. Даниел болон түүний гурван найз хүмүүстэй эв нэгдэл хагалахаасаа өмнө Бурхантай эв нэгдлийг сахисанаараа Бурханыг гайхамшигтайгаар алдаршуулсан талаар Даниел 3-р бүлэгт гардаг.

Даниелын гурван найз Вавилоны Небухаднезар хааны хиймэл шүтээнд мөргөж хүндэтгэл үзүүлээгүйгээсээ болоод шатаж буй гал руу хаягдах аюултай тулгарсан.

Тэд хаантай эвдрэлцэж муудалцахгүйгээр зүгээр л нэг удаа хиймэл шүтээнд нь мөргөж болох л байсан. Гэвч энэ бол Бурханы мэлмийд асар том гэм нүгэл учраас Бурхантай эв нэгдэл хагалах байсан юм. Тэд хаантай эвдрэлцэж амь нас нь аюулд орлоо ч Бурхантай л эв нэгдэлтэй байхыг сонгосон.

Эцэст нь, тэднийг ердийн шатаж байгаа зуухнаас долоо дахин халуун галд тэднийг хаяхыг тушаасан. Гэтэл Бурхан хамгаалсан учраас тэд ердөө ч түлэгдэж, шархдаагүй, толгойноос нь нэг ширхэг үс ч түлэгдээгүй. Энэ гайхамшгыг үзсэнийхээ дараа хаан агуу Бурханыг алдаршуулж, нөгөө гуравын байр суурийг ч өндөрт тавьсан юм.

2. Бурханы хүлээн зөвшөөрөх зөвт байдлыг үр жимсийг гаргахын тулд

Энэ дэлхийд хүн хичнээн ууртай, атаархуу, үзэн яддаг, хэрүүлч, шунахай сэтгэлтэй байсан ч тэр сэтгэл нь бодитоор үйлсээр илчлэгдээгүй бол тийм хүнийг хорон муу эсвэл бүдүүлэг гэдэггүй. Харин Бурханы өмнө хичнээн тийм юм үйлдээгүй ч сэтгэлдээ дээр дурьдсан чанарууд байвал хэдийнээ хорон муу хүн юм. Энэ мэт Бурханы хүсэж буй зөвт байдал, ба хүний бодож буй зөвт байдал хоорондоо асар их ялгаатайг харуулж

байна.

Библи бидэнд зарим зүйлийг хий, бүү хий, сахь, хая гэсэн заавар, тушаал байдаг. Энэ дагуу өө сэвгүй амьдарч чадвал Бурханы мэлмийд зөвт байдлыг бий болгож чадна. Тиймд хүний үүднээс харагдах зөвт байдлаас илүүтэйгээр Бурханы мэлмийд зөв харагдах зүйлсийг бид сонгож үйлдэх хэрэгтэй.

Харин зарим хүмүүс Бурханд итгэдэг гэсэн мөртлөө элдэв тахилга шүтлэгийн үйлд оролцох юм уу, мэрэгч төлөгч дээр очиж байгаагаа зүгээр л ‘уламжлал, ёс заншил’ учир зүгээр гэж боддог. Манай улсын ёс заншил учир яалтай билээ? хэрвээ мөргөөгүйгээсээ болоод итгэгч биш гэр бүлийнхнээ гомдоовол дараа нь сайн мэдээ тараахад хэцүү байх болно гэж ярьцгаадаг. Гэвч энэ нь сүнс талаараа бол дайсан сатан диаволд захирагдаж, түүнд мөргөж байна гэсэн үг юм. Хэрэв Бурхантай эв нэгдэл хагалбал Бурхан цаашид туслах боломжгүй бөгөөд гэр бүлд сайн мэдээ тараах ажил ч улам хэцүү болох болно.

Сургаалт Үгс 16:7д “Хүмүүний зам ЭЗЭНий таалалд нийцэх цагт Тэрээр түүний дайснуудыг нь хүртэл түүнтэй эв түнжинтэй байлгадаг” гэжээ. Энд бичсэнээр бид эхлээд Бурхантай эв нэгдэлтэй байвал бусад хүмүүстэй ч бас эв нэгдэлтэй байна гэсэн байна. Хэрэв Бурхантай эв нэгдэл хагалаад бусадтай эв нэгдэлтэй байвал цаг ямагт л хоорондоо эвдрэлцэж, бидэнд ямар ч ашиг тусгүй байх болно. Бид зөвхөн Бурханы мэлмийд тааламжтайг сонгоод байлгүй мэргэн ухааныг хүлээн авч шийдвэрлэх аргыг суралцах хэрэгтэй. Тэгвэл залбирлын хариулт болон ивээл ерөөлийг илүү ихээр хурдан авч, бүх хүнтэй эвтэй байж чадна.

Бурхантай эвтэй байна гэдэг нь зөвхөн Бурхан бидний хооронд байдаггүй, Бурханы бүх гэрт итгэмжтэй байхад хамаатай юм. Бурханы бүх гэрт итгэмжтэй байх гэдэг нь амьдралынхаа бүх салбарт итгэмжтэй байхыг хэлнэ. Ийм итгэлтэй хүмүүс үйлчлэл, золиос, хайр, харамгүй сэтгэлээр бусадтай эв нэгдэлтэй байж чадна. Ингэж бид Бурхантай эв нэгдэлтэй байвал зөвт байдал болж чадах бөгөөд сүнсээрээ амар тайван байж, юу ч гуйсан хариултаа авч, хаа ч байсан зөвт байдлын үр жимсийг гаргаж чадна.

3. Бурхантай эв нэгдэлтэй байвал дээрээс ирэх мэргэн ухааныг авна

Адамын удам болсон бүх хүн төрлөхтөн гэмтэн болж ариун Бурхантай эв нэгдэл хагарсан юм. Гэвч ямар ч гэм нүгэлгүй Есүс бидний төлөө загалмайд цовдлогдсноор гэмээ цагаатгуулах болсон.

Тэр биднийг Бурханыг хүүхэд болох мөн Есүс Христэд итгэсэнээр Бурхантай эвлэрэх замыг нээж өгсөн юм.

Ром 5:1д “Тиймээс итгэлээр зөвтгөгдсөн бид бидний Эзэн Есүс Христээр дамжуулан Бурхантай эвлэрсэн билээ” гэсэн байдаг. Тэгэхээр одоо гэм нүглээсээ уучлагдаад дуусах биш харин явал Бурхантай эвлэрэх боломжтой вэ? Нэгэнт бид итгэлээр зөвтгөгдсөн бол жинхэнэ итгэлтэй болж итгэлээр өсч, үйлс дагуулах ёстой. Хорон муугаа, гэм нүглээ хаяж, зүрх сэтгэлдээ Бурханы зөвт байдлыг бий болгох хэрэгтэй.

Хэрэв бид харанхуй дотроо гэм нүгэлдээ хутгалдан амьдарсаар байвал Бурхантай эвлэрч чадахгүй эв түнжин хагарах болно. Бурхан бидэнтэй эвлэрэхийн тулд Өөрийн цорын ганц хайртай Хүүгээ золиос болгосон тул бид одоо өөрсдийнхөө зүгээс энэ эв нэгдлийг хагалах хэрэггүй юм. Харин бид өөрсдийн хорон муу атгаг байдал, гэм нүглээ түргэн хаях хэрэгтэй. Ингэж чадвал Бурхантай бүр ойртож, илүү гүн гүнзгий дотно харилцаатай болж чадна. Бид зөвт байдлын үр жимсээр дүүрэх ёстой юм.

Бурхантай эвлэрч чадсан хүмүүс бусадтай ч эвлэрч бас чаддаг учраас асар их ивээл ерөөлийг авдаг. Мосе Бурханы өмнө итгэл хүлээсэн хүн байсан учраас Израйлийн бүх хүүхдүүд хүртэл уучлагдаж, Бурханы өршөөл нигүүлслийг хүртэж байсан. Хүмүүс Бурханд гомдоллож, маш хүнд гэм нүгэл үйлдэж, алтан тугал хийгээд түүндээ мөргөж, хүндэтгэж байсан. Тэгэхэд Мосе өөрөө там унаад ч болов тэднийг аврахыг Бурханаас гуйж байсан.

Энэ мэт Бурхантай эвлэрсэн хүмүүс амар тайван байж, олон хүмүүстэй дээрээс ирэх мэргэн ухаанаар эвтэй байдаг бөгөөд тэднийг ивээл, ерөөлийн замаар удирдан дагуулж чаддаг юм. Бурханы мэргэн ухаан бол Библид бичигдсэн Бурханы үг мөн. Мэргэн ухаан нь дээрээс ирдэг ч Түүний тушаалыг сахиж, гэм нүглээ хаясан цагт Ариун Сүнсний удирдамжийг хүлээн авч хорон муугаас чөлөөлөгдөж зүрх сэтгэлээ ариусгаж чадна.

Хайрт итгэлийн ахан дүүс нар минь, та бүхэн Иаков 3:17д гардаг ариун, амар тайван, эелдэг, ул суурьтай байх гэсэн чанарыг зүрх сэтгэлдээ гүн шингээж, бүх хүмүүстэй төдийгүй Бурхантай төгс эв нэгдлийг бий болгохыг хүсэж байна. Тэгж эв нэгдлийг тогтоосноороо Бурханы ивээл амар амгалан дотор арвин их зөвт байдлын үр жимс ургуулснаар Тэнгэрийн оронд нар гэрэлтэх алдрыг хүлээн авахыг Их Эзэний нэрээ хүсэн ерөөе.

Монгол Манмин Сүм

Мэргэлийн цаг

Мэргөл	Цаг
Их мэргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мэргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мэргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мэргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мэргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мэргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.gcntv.org



Ариун Сүнсний бэлэг гэж юу вэ?



1 Коринт 12:4-11д Ариун Сүнсний ажилд үйлст хэрэгцээ шаардлагаар нь хүн тус бүрт өгөгддөг бэлэг авьяасууд тухай гардаг ба бид энэхүү бэлэг авьяасын тухай ойлгож, энэ бэлэг авьяасыг авахын тулд хүсэн тэмүүлж, чин сэтгэлээсээ гуйн залбирснаар хүлээн авч, авсанаар хүчирхэг итгэлийн амьдралаар амьдрахыг хүсье.



1. Мэргэн ухааны үгийн бэлэг

Хэрэв бид энэ мэргэн ухааны үгийн бэлэг авьяасыг авбал Бурханы үгийг яг тохирсон үед нь хэзээ, хаана хэрэглэхээ мэддэг тул хүмүүсийг хурдан өөрчлөгдөхөд нь туслаж чаддаг.

*

Ариун Сүнс хүний зүрх сэтгэлийг шинэчилж, хүмүүсийг урамшуулж, зоригжуулдаг, амьдралыг талархал, баяр жаргалтай болгож өөрчилдөг. Мөн түүнчлэн итгэлийг өгч, тэнгэрийн орны итгэл найдвараар дүүргэдэг учраас хүмүүс дэлхийг ялан дийлж чаддаг юм. Ариуслыг олж авах нь Бурханаас өгөгддөг мэргэн ухаан юм (Иаков 3:17-18). Хэрэв бид энэхүү бэлгийг авбал ямар ч ажлыг хийж чадах сүнслэг хүчтэй болно.

2. Мэдлэгийн үг

Бид Бурханы үгийг сүнс зүгээр зэвсэглэхийн тулд хамгийн түрүүнд үгийг ойлгох чадвартай сүнсний нүд хэрэгтэй. Тэгж чадахгүй бол бид зөвхөн үгчилэн ойлгох төдийгүй дотор нь агуулагдаж буй жинхэнэ утгыг нь ойлгож чадахгүй тул Бурханы хайр, Түүний зүрх сэтгэлийг ч ойлгож, мэдрэхгүй юм.

*

Иймд Бурханы үгийг сүнслэгээр зэвсэглэхгүй бол бид Бурханы үгийн дагуу үйлдэж чадахгүй бөгөөд Бурханы хүч нөлөөг ч хүлээж авч чадахгүй юм. Зөвхөн мэдлэгийн үгийн бэлэгийг хүлээн авсанаар Библийн сүнслэг утгуудыг нь ойлгож тэдгээрийг өөрсөдөө шим тэжээл болгон хэрэгжүүлж болох юм.

3. Итгэлийн бэлэг

Бурханаас өгөгдөх итгэлийг авахын тулд Ариун Сүнсний тусламжыг авах хэрэгтэй. Энэ нь бид Бурханы Үгийн мэдлэгээ үйлс болгон үйлдэхэд маш чухал бэлэг юм.

*

Сайхан сэтгэлтэй хүмүүс Бурханы үгийг сонсон өөрт байгаа зохисгүй байдлаа олж мэдэн мөс чанараа даган ямар ч эргэлзээгүйгээр дутагдлаа засдаг. Түүнчлэн Бурхантай уулзан мэдрэх буюу Бурхан амьд оршин байгаа баталгааг нүдээрээ үзвэл шууд л Бурханы хүчийг хүлээн зөвшөөрөн итгэдэг. Ийм хүмүүс нь Итгэлийн бэлгийг хүлээн авсан учраас эдгээрийг мэдрэх боломжтой юм.

4. Эдгээх бэлэг

Эдгээх бэлэг авьяас гэж аливаа вирусын гаралтай өвчнүүдийг залбиралаар эдгээх чадварыг хэлдэг.

*

Хүнд өвчин туссан хүн ч хүртэл өөрийнхөө бүх буруутай үйлс, гэм нүглээ хүлээн зөвшөөрч, чин сэтгэлээсээ гэмшиж, эдгээх бэлэг авсан хүнээр залбируулвал эдгэрэх боломжтой. Мөн үнэнийг мэдэхгүй үедээ гэм нүгэл үйлдсэн хүн ч хэрэв чин сэтгэлээсээ гэмшвэл Бурхан түүнийг уучлан өршөөж эдгээж өгч болно. Мөн тэр хүн эдгэрлийн бэлэг авьяас авсан хүнээр залбируулвал бүр ч хурдан бас их амархан эдгэрч болно.

5. Гайхамшигийг үйлдэх бэлэг

Гайхамшигийг үйлдэх бэлэг авьяас нь хүний хүч чадлаар хийх боломжгүй тахир дутуу, дауны хам шинж өвчин буюу төрөлхийн ургийн гажиг өвчнийг хүртэл эдгээж, цаг агаар, тэнгэр огторгуйг хүртэл захирч, хүний зан араншинг өөрчилж чадах үйлсийг хэлж байгаа юм.

*

Энэ бэлэг авьяас нь Бурханы хүсэлд нийцтэй хүнд өгөгддөг. Хүмүүс итгэлийн дөрөв дүгээр шат буюу Бурханы туйлын ихээр хайрладаг болсон үед л хүний чадвараас хол илүү давсан итгэмээргүй гайхамшигийг үзүүлэх боломжтой болдог. Бурханыг маш ихээр хайрлах итгэл, чин сэтгэлийн гал халуун залбиралыг хурааж байж илүү гүнзгий түвшин руу орно.

6. Эш үзүүлэх бэлэг

Эш үзүүлэг нь Бурханы хүсэл дотор Ариун Сүнсний дүүрэлт, сүнсний бялхам байдал дотор ирээдүйн байдлыг урьдчилан хэлэхийг хэлдэг. Энэ Эш үзүүлэгч хүмүүсийг босгон байгуулах, урамшуулах, тайтгаруулахын тулд ярьдаг (1 Коринт 14:3).

*

Эш үзүүлэх бэлэг авьяас нь маш их залбирдаг Бурханы үгийг дуулгавартай дагадаг, сэтгэл зүрхэндээ хорон муугийн ямар ч хэлбэргүй ариун хүнд өгөгддөг. Тэд Ариун Сүнсээр дүүрч, Түүний хүч чадлаар ярьдаг учраас юу ярьж байгаагаа мэддэггүй.

7. Сүнснүүдийг ялгах чадвар

Сүнсийг ялгах гэдэг нь “Бурханы хүслийг мэдэх” гэсэнтэй адил бөгөөд энэ бэлэг авьяасыг авахын тулд Бурханы үгэнд бүрэн дуулгавартайгаар дагах хэрэгтэй. Ариун Сүнсний дууг ойлгож Бурханы хүслийг даган хэрэгжүүлэх үед Бурханы хүчээр сүнсийг ялгаж чадна.

*

Сүнсийг ялгах төгс шатанд орвол сүнс болоод махан биеийн зүйлсийг ялгаж чаддаг болохоос гадна Ариун Сүнсний дуу хоолой, ба миний бодол санаа, сайн ба хорн муу, үнэн ба худал хуурмагыг ялгах чадвартай болно гэсэн үг юм. Мөн атгаг сүнсэнд баригдсан юмуу уруу татагддаг хүмүүсийг ялгаж чадах маш хурдан асуудлыг шийдэх боломжтой юм.

8. Харь хэлээр ярих бэлэг

Харь хэлээр ярих бэлэг нь итгэлийн амьдралд маш хэрэгтэй тул Бурхан Ариун Сүнс хүлээж авсан хүүхэд бүртээ өгөхийг хүсдэг бэлэг юм.

*

Харь хэлээр залбирах нь Ариун Сүнсний хамт залбирах залбирал юм. Ингэж залбирах үед Ариун Сүнсээр дүүрч Бурханы үгийг илүү сайн ойлгож чаддаг. Бид чин сэтгэлээсээ залбирах чадвартай болдог бөгөөд Ариун Сүнсээр дүүрч хүчийг авахад тусладаг. Мөн сорилт, бэрхшээл, зовлон шаналалыг даван гарч хаяхыг хүссэн зүйлсээ ч хаях чадвартай болдог. Ингэж харь хэлээр залбирахад зөвхөн Бурхан л сонсох боломжтой учир сатан энэ бүхнийг нууцыг тайлж чаддаггүй юм.

9. Харь хэлийг тайлбарлах бэлэг

Энэ нь Ариун Сүнсээр дүүрсэн хүн харь хэлийг тайлбарлаж чадна. Гэхдээ энэ бэлэг нь зөвхөн Бурханы онцгой хүсэл дотор зайлшгүй хэрэгтэй хүнд эсвэл төгс ариуссан хүмүүст өгөгддөг бэлэг юм.

*

Эш үзүүлэг болон харь хэлийг тайлбарлах бэлэг авьяасыг авахын тулд өөрийн бодол санааг хянах, зогсоох чадвартай байх хэрэгтэй. Бурхан эш үзүүлэг өгсөн ч бидэнд энэ төрлийн чадвар байхгүй бол эш үзүүлэхдээ, эсвэл хэлийг тайлбарлахдаа өөрийн бодол санаатайгаа холилдог учраас юм. Ялангуяа үнэний дотор амьдарч чаддаггүй хүн нь сатаны ямар нэгэн хэмжээгээр нөлөөг авах боломжтой учраас Бурхан эдгээр бэлгүүдийг үнэн дотор амьдардаггүй хүнд өгөх боломжгүй.

Израйлийн Андре Гасиоровски захирал Манмин төв сүмийн 32 жилийн ойн баяраар зочлон очлоо. Түүнтэй хийсэн ярилцлагаа та бүхэнд толилуулж байна.



“Манмин Төв Сүм бол хайраар дүүрэн хүмүүсийн цугладаг газар юм”



Израиль, Андре Гасиоровски захирал (55настай)

Тусламжийн Гар холбооны ерөнхий гүйцэтгэх захирал
Чих хамар хоолойн эмч, эх баригч, эмэгтэйчүүдийн эмч
Интернет, С.Е.О, Мэдээлэл Технологийн Группын ерөнхийлөгч

Та Бурханы ерөөлийг авахын тулд юуг гол зарчим болгодог вэ?

Би энэ дэлхийд мэндэхээсээ ч өмнө ээжийнхээ залбирлаар Бурханд өргөгдсөн байсан. Би Польшид төрсөн еврей хүн л дээ. Залуу байхдаа хамран ажилладаг хүнийхээ санал болгосноор нэгэн бизнесийг эхлүүлсэн юм. Би эмч мэргэжилтэй болохоор бизнесийн талаар жаахан эргэлзэж байсан ч түүний саналыг итгэлээрээ хүлээн авч “Бусадтай хуваалцахын тулд бид ажилладаг!” гэсэн уриатай ажлаа эхэлж, аравны нэгээ Бурханд өргөдөг байлаа. Бурханы ивээл ерөөл бидэн дээр буун ирж, бизнес маань цэцэглэж 600 гаруй салбартай болж, сая саяар тоологдох гайхамшигтай их ашиг орлого олдог болсон.

Манмин төв сүмийн талаар та Израйльд хаанаас олж сонссон бэ?

Би тусламжийн Гар холбооны захирал (фашистын олзлогдоос амьд гарсан еврей хүмүүст онцгой анхаарал тавьдаг олон улсын хүмүүнлэгийн байгууллагын зуу зуун сүлжээ). Фашистуудаас амьд үлдэгсэд бол маш хүнд хавчлага дарамт дор байсан хамгийн өрөвдмөөр хүмүүс юм. Тиймээс би жил бүр тэдэнд зориулсан үйл ажиллагаа зохион байгуулдаг. 2012 онд Манмин Төв Сүмийн И Сү жин Пастор ирж 10,000 гаруй амьд үлдэгсэд амийн үгийг дамжуулж, сүмийн урлагын тоглолтыг үзүүлсэн. Энэ цуглаан тэдний зүрх сэтгэлийг нээж Эзэнийг сонирхож, итгэх хүслийг нь төрүүлж өгсөн юм.

Манмин сүмд зочлоход хамгийн их сэтгэл хөдөлгөсөн зүйл тань юу вэ?

Би энд ирээд харсан зүйл нь бүх итгэгчид Ариун Сүнсний удирдлага дор мөн Ариун Сүнсний хүсэж буй зүйлд дуулгавартай байгааг харсан юм. Манмин төв сүм бол хайраар дүүрсэн итгэгч нарын цуглардаг газар бөгөөд миний харсан хүн бүр хайр ба амар тайвнаар дүүрэн бөгөөд тэнгэрийн орон Шинэ Иерусалимд орох хүсэл тэмүүлэл оргилж байдаг. Тэд Бурханы тушаалуудыг сахиж, ариуслыг олж, Шинэ Иерусалим заавал орно гэсэн тусгай зорилготой. Тэд яг л урьдаас тэнгэрийн орны амьдарлаар амьдрах дасгал хийж байгаа юм шиг санагдсан. Бүх хүн энэ Манмин Сүмийн сүнслэг урсгалаар дамжуулан Бурханд яаж үйлчлэхийг сурна гэдэгт би итгэлтэй байна.

И Жей руг Пастортой анх уулзаад ямар сэтгэдэл төрж байсан бэ?

Би анх И Жей руг пастортой уулзах үед гайхамшигтай мэдрэмжээр дүүрэн байсан. Би түүний зурагыг харж, сургаалыг нь сонсож байсан ч яг үнэндээ би түүнээс жаахан айж байсан. Харин тэр яг л эцэг эхийн хайраар дүүрэн аав шиг хүн байсан.

Тун ч удалгүй түүний сүнслэг байдал болоод хайрыг харж, бүх зүйлийг хайран дотор хийдэг болохыг мэдэрч ийм олон хүн яагаад түүнийг хайрладаг болохыг ухаарсан. Мөн түүгээр дамжуулан Бурханы оршихуйг мэдэрсэн. Тэр дэлхийн зүйлтэй эвлэрдэггүй Бурханы ариухан боол болохыг мэдсэн. Зөвхөн Бурхантай харьцаж түүний хайрыг хүмүүст дамжуулж байгаа нь түүний амьдарч байгаа гол утга учир нь юм шиг санагдсан.

Та цаашдынхаа үйлчлэл болон алсын харааныхаа талаар бидэнд ярьж өгнө үү?

Телевизээр Израйлын мэдээ гарч GCN (Жи Си Эн)-г үздэг үзэгчидэд манай орон илүү ойр дотно болно гэдэгт итгэлтэй байна. Нэмж хэлэхэд, GCN-н хөтөлбөр Израйлаас дэлхий дахинд цацагдаасай гэж хүсч байна. Хэрэв ариун зар мэдээ Иерусалимаас гарвал дэлхийн хүмүүст гайхалтай нөлөөлөх болно.

Миний зүрхний гүнийг хүртэл мэддэг Бурхан

Со Ми геон халамжлагч, 46 настай, Өмнөд Солонгос

2014 онд Эзэний хайран дотор гайхамшигыг үзсэн юм. 11-р ангийн сурагч байхад ээж маань мөнгө олохоор намайг орхиод явсан. Түүнээс хойш манай гэр бүлийнхэн 27 жилийн турш түүнтэй холбоо тасарсан. Бид түүнийг олохыг хичээж сонинд хүртэл хандаж үзсэн ч бүх зүйл талаар болсон.

Би амьд Бурханд итгэдэг болсноос хойш би чин сэтгэлээсээ залбирч, мөргөлийн үеэр И Жей руг пасторын өвчний төлөөх залбирал хийж байхад би өөрийн сэдвээрээ итгэлээрээ залбирал авсан юм. Гэтэл 2014 онд 27 жилийн дараа ээжийгээ олж жинхэнэ гайхамшигыг өөрөө мэдэрсэн. Тэгээд манай гэр бүлийнхэн бүгдээрээ Чусок (Солонгосын үндэсний баяр болох Ургацын баяр) баярыг 2014 онд



ээжтэйгээ хамдаа баяр хөөр дүүрэн тэмдэглэсэн.

Түүнчлэн би И Жей руг пасторын өвчний төлөөх залбирлыг авахын өмнө зүрхнийхээ гүнд байх гомдол, дургүйцэл, үзэн ядалтаа ухааран хаяханд Ариун Сүнсний халуун байдлыг мэдэрч билээ. Энэ үйл явдал 2014 оны 8 сард болсон зуны цуглаанаар И Жей руг тэргүүн пастор өвчтэй хүмүүсийн төлөө залбирахад би ээждээ гомдож, түүнийг үзэн ядаж байгаагаа шууд ухаарч ойлгоод гэмшсэн. Тэгээд Ариун Сүнсний гал над руу ирж байгааг мэдэрсэн. Залбирал авч байх үед давхраатай болохыг хүсч гараараа нүдээ дарж авсан юм.

Гэтэл залбирлын дараа маш гоё давхраатай болсон байв. Халлелуяа! Бүх алдар магтаал, хүндэтгэлийг хайраараа шархалсан зүрхийг минь эдгээж, зүрх сэтгэлийг минь хүсэл тэмүүлэлээр дүүргэж өгсөн Бурхандаа өргөж байна.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57-тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29-тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин